

БАТЛАВ  
НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН  
ГАЗРЫН ДАРГА *D. Batsu* Д.БАТСҮХ

2022 оны 06 дугаар сарын 22

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ  
/2022 он/

2022 оны 06 дугаар сарын 22

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт
Нэг.Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт, томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.1.1.Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хариуцлагыг дээшлүүлэх	1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилно.	Тухайн жилд	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.
	2	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил тод нээлттэй болгоно.	Тухайн жилд	Хүний нөөцийн жагсаалтын бүртгэлийг ил тод нээлттэй болсон байх
	3	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.	I улиралд	Ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байх
4.1.1.2.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын	4	Албан тушаалтанд тавигдах ёс зүйн, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.	Тухайн жилд	Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг

шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох дэвшүүлэх				холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилсон байх
	5	Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулна.	Тухайн жилд	Төрийн албаны нөөц нэмэгдсэн байна.
4.1.1.3. Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	6	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнг мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангана.	Тухайн жилд	Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үр дүн, мэргэшлийн түвшинг үнэн зөв шударгаар үнэлж урамшуулал олгох
4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүлээн авч шийдвэрлэнэ.	7	Албан тушлаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүлээн авч шийдвэрлэнэ.	Тухайн жилд	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн зөвлөл, хяналт шалгалт дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх
Хоёр. Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчилгээний эрх ашигийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.2.1. Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	8	Онлайн бизнес төв дэд төсөл хэрэгжүүлнэ.	Тухайн жилд	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, хамгийн хялбар, шуурхай байдлаар иргэн аж ахуй нэгжид хүргэсэн байх
4.1.2.6. Өргөдөл гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх	16	Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэлтийн чанар үр дүнг сайжруулна.	Тухайн жилд	Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх
	17	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг дотоод	Тухайн жилд	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан

		удирдлагын нэгдсэн UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд цэсний хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулж, программ хангамжийн сургалтуудыг зохион байгуулан ажиллана.		тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн батлуулсан байх
	18	Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөж, эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлж, иргэнд хариуг тухай бүр өгч ажиллана.	Тухайн жилд	Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөн эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, иргэнд хариу өгсөн байх
Гурав.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр				
4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	22	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын нэгдсэн цахим хуудсанд “Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.	Тухайн жилд	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үйл явц гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх

ХЯНАСАН:

ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРДОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.СОДНОМДЭМБЭРЭЛ

БОЛОВСРУУЛСАН:

ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ ДОТООД  
АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
Б.ЭНХЦЭЦЭГ

НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗАР

АВИЛГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ХҮРЭЭНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТАЙЛАН  
/2022 оны 3 дугаар улирлын байдлаар/

2022 оны 10 дугаар сарын 03

Улаанбаатар хот

Үндэсний хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаа	№	2022 онд хэрэгжүүлэх арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх түвшин үр дүнгийн үзүүлэлт	Үр дүн
Нэг.Шударга, хариуцлагатай, ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авилгын эрсдэлээс урьдчилан сэргийлэх, төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
4.1.1.1.Төрийн албаны төв байгууллагын дүгнэлт, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг хянасан байдлыг үндэслэн албан тушаалд томилох тухай хуулийн хэрэгжилтийг хангаж хариуцлагыг дээшлүүлэх	1	Төрийн албаны зөвлөлийн болон салбар зөвлөлийн дүгнэлт нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг (ХАСУМ)-ийг хянасан дүгнэлтийг үндэслэн албан тушаалд томилно.	Тухайн жилд	Хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангасан байна.	Төрийн албаны зөвлөл болон Авилагтай тэмцэх газрын Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийн дүгнэлтийг үндэслэн удирдах албан тушаалд 1, гүйцэтгэх албан тушаалд 3, нийт 3 албан хаагч томилогдсон. Засгийн газрын 194 дүгээр тогтоолын хүрээнд ТЗ-6 ангилал руу шилжиж буй 10 албан хаагч, хөрөнгө орлогот нь их хэмжээний өөрчлөлт орсон 2 албан хаагч, шинээр томилогдсон 1 албан хаагч хөрөнгө орлогын мэдүүлгийн гаргаж, холбогдох газарт тайлагнасан.
	2	Төрийн захиргааны төв байгууллагын хүний нөөцийн жагсаалт, төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, төрийн албаны тухай хуульд заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн төрийн албан хаагчийн нөөцийн бүртгэлийг ил	Тухайн жилд	Хүний нөөцийн жагсаалтын бүртгэлийг ил тод нээлттэй болсон байх	Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн судалгааг гаргаж газрын сайтын Ил тод цэсийн Хүний нөөц цонхонд байршуулсан. Жирэмсний буюу хүүхэд асрах чөлөөтэй 2 албан хаагч, урт хугацаатайгаар сургалцахаар түр чөлөөлөгдсөн 1

		тод нээлттэй болгоно.			албан хаагч нийт 3 албан хаагч
	3	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн батлуулна.	I улиралд	Ажлын байранд тавигдах нийтлэг шаардлагыг баталсан байх	Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 323 дугаар тогтоолоор газрын 14 албан хаагчийн албан тушаалын тодорхойлолт шинэчлэн баталсан. Албан тушаалын тодорхойлолтыг тус бүрээр нь сайтад байршуулсан.
4.1.1.2.Нийтийн албанд томилогдох албан тушаалтны ёс зүй мэдлэг, боловсрол, туршлага, ур чадварын шалгуурыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, албан тушаалтныг мэдлэг боловсролд суурилсан мерит зарчмыг баримтлан томилох дэвшүүлэх	4	Албан тушаалтанд тавигдах ёс зүйн, мэдлэг боловсрол, туршлага, ур чадварын ерөнхий болон тусгай шалгуурыг үндэслэн дэвшүүлэн томилно.	Тухайн жилд	Албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлагыг хангасан иргэнийг холбогдох журмын дагуу сонгон шалгаруулж томилсон байх	Төрийн захиргааны албан тушаалын тодорхойлолтод заасан тусгай шаардлага хангасан 4 албан хаагчийг шинээр ажилд томилон ажиллаж байна.
	5	Төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтыг зохион байгуулна.	Тухайн жилд	Төрийн албаны нөөц нэмэгдсэн байна.	2022 онд Төрийн албаны ерөнхий шалгалт өгсөн 2 албан хаагч байна. Үүнээс 1 сул ажлын байран дээр тусгай шалгалтыг зарлуулахаар Нийслэл дэх Төрийн албаны салбар зөвлөлд хүргүүлээд байна.
4.1.1.3.Олон улсын жишигт нийцсэн гүйцэтгэлийн үнэлгээний нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, нийтийн албан тушаалтны үйл ажиллагааг үнэлэх, дүгнэх, хариуцлага тооцох арга хэлбэрийг шинэчлэн тодорхойлох эрх зүйн зохицуулалтыг бий болгох	6	Засгийн газрын 2020 оны 218 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүнг мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын хэрэгжилтийг хангана.	Тухайн жилд	Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үр дүн, мэргэшлийн түвшинг үнэн зөв шударгаар үнэлж урамшуулал олгох	Шинээр томилогдсон 1 албан хаагчтай хэлтэс нэгжийн дарга гүйцэтгэлийн төлөвлөгөө батлан ажиллаж байна.


4.1.1.7. Нийтийн албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах хариуцлага хүлээлгэх арг хэлбэрийг тодорхой болгож, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэх	7	Албан тушаалтанд холбогдох авлига, ашиг сонирхол, ёс зүйтэй холбоотой өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, хянан шалгах, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл хүлээн авч шийдвэрлэнэ.	Тухайн жилд	Өргөдөл, гомдол, мэдээллийг хянан шалгах ёс зүйн зөвлөл, хяналт шалгалт дотоод аудитын нэгжийн үйл ажиллагааны үр дүн сайжирсан байх	Газрын даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/14 дүгээр тушаалаар Ёс зүйн зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулж 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг баталсан. 3 дугаар улирлын байдлаар албан хаагчдыг ёс зүйн зөрчлөөс урьдчилан 5 албан хаагчийн “Төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа” сургалтад хамруулсан. Ёс зүйн зөрчил гаргасан албан хаагч байхгүй болно.
Хоёр.Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж, чанар хүртээмжийг сайжруулах, үйлчилгээний эрх ашигийг дээдэлж, төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
4.1.2.1.Төрийн үйлчилгээг иргэнд цахим хэлбэрээр хүргэх тогтолцоог бүрдүүлэн, цахим үйлчилгээний нэгдсэн сүлжээ бий болгож, бэхжүүлэх	8	Онлайн бизнес төв дэд төсөл хэрэгжүүлнэ.	Тухайн жилд	Тусгай зөвшөөрлийн үйлчилгээг бүрэн цахимжуулж, хамгийн хялбар, шуурхай байдлаар иргэн аж ахуй нэгжид хүргэсэн байх	<a href="https://service.ulaanbaatar.mn/">https://service.ulaanbaatar.mn/</a> цэсээр дамжуулан иргэд үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг олгох ажлыг хялбаршуулан ажиллаж байна.
4.1.2.6.Өргөдөл гомдол, мэдээлэл өгөх ил тод, нээлттэй суваг ажиллуулах, өргөдөл, гомдол, мэдээллийг цахим хэлбэрээр гаргах, шийдвэрлэх, хяналт тавих нөхцөл боломжийг бүрдүүлэх	16	Иргэдээс нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг хүлээн авч шийдвэрлэлтийн чанар үр дүнг сайжруулна.	Тухайн жилд	Эх үүсвэрийн тоог нэмэгдүүлж өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хяналтыг сайжруулсан байх	3 улирлын байдлаар нийт 20 өргөдөл, гомдол, хүсэлт ирсэн. 2021 оны III улирлын байдалтай харьцуулахад өргөдөл, гомдол 59 хувийн өсөлттэй бөгөөд шийдвэрлэлтийн хувь 100%, 6 хоног 14 цаг 11 минут байна.
	17	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд цэсний хөгжүүлэлтийн ажлын	Тухайн жилд	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх журмыг шинэчлэн батлуулсан	Нийслэлийн нутгийн захиргааны байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг дотоод удирдлагын нэгдсэн UB ERP системийн өргөдөл, гомдлын дэд цэсийн хөгжүүлэлтийн ажлын

		даалгаврыг боловсруулж, програм хангамжийн сургалтуудыг зохион байгуулан ажиллана.		байх	даалгаврыг боловсруулж, программ хангамжийн сургалтуудыг зохион байгуулан шинээр орсон 5 албан хаагчид зааж, цаг тухай бүрд мэдээллийг шинэчлэн ажиллаж байна.
	18	Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөж, эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг шийдвэрлүүлж, иргэнд хариуг тухай бүр өгч ажиллана.	Тухайн жилд	Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирүүлж буй нийтийн эрх ашиг зөрчигдөн эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлж, иргэнд хариу өгсөн байх	Олон нийтийн сүлжээгээр иргэдээс ирсэн 2 хүсэлтийг тухай өдөрт нь холбогдох албан хаагчид өгч хүсэлт гаргасан иргэнтэй холбогдон 100% шийдвэрлэсэн. Нийтийн эрх ашиг зөрчигдөж, эцэслэн шийдвэрлэгдэхгүй байгаа өргөдөл, гомдол байхгүй болно. Өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн талаар тухай бүр газрын хурлаар танилцуулж, нийслэлийн Засаг даргын тамгын газрын Үйлчилгээний нэгдсэн төвд улирал бүр өргөдөл гомдлын тайланг хугацаанд нь хүргүүлэн ажилласан
Гурав.Төсөв, санхүү, аудитын үйл ажиллагааны удирдлага, хяналтыг сайжруулах, ил тод байдлыг хангах, төсвийн хөрөнгө, гадаадын зээл тусламжийг үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулах, хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр					
4.1.3.3. Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтыг ил тод, хяналттай болгох	19	Засгийн газрын тусгай сангийн санхүүжилт, зарцуулалтын нэгдсэн цахим хуудсанд "Засгийн газрын тусгай сангийн мэдээлэл гэсэн цэсээр олон нийтэд мэдээлэх ажлыг зохион байгуулна.	Тухайн жилд	Хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөрийн үйл явц гүйцэтгэлийг цахимаар хянах боломжийг судалж, хэрэгжүүлсэн байх	Төсвийн ил тод байдлыг хангах иргэдэд нээлттэйгээр зарцуулалтад хяналт тавих боломжийг бүрдүүлж, tender.gov.mn, shilendans.gov.mn, https://tourism.ub.gov.mn/ сайтуудад тухай бүрт байршуулан ажиллаж байна.

ТАНИЛЦСАН:  
 ДАРГА *D. Batsu* Д.БАТСҮХ



ХЯНАСАН:  
ЗАХИРГАА, САНХҮҮГИЙН ХЭЛТСИЙН ДАРГЫН  
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Х.СОДНОМДЭМБЭРЭЛ



ТАЙЛАН НЭГТГЭСЭН:  
ХҮНИЙ НӨӨЦ, ЁС ЗҮЙ ДОТООД  
АЖИЛ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН  
Б.ЭНХЦЭЦЭГ

